



**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар Б/М

Улаанбаатар хот

**Ч.Аюурзанын Хөдөлмөр эрхлэлтийн
харилцааг дуусгавар болгох тухай**

Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 79.3, Компанийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, 14.4.6-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлах санал гаргасан Захиргаа, удирдлагын нэгжийн Ерөнхий нягтлан бодогч Чүлтэмийн Аюурзаныг 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосугай.

2. Ч.Аюурзанад 3 /гурав/ сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1 /нэг/ удаагийн тэтгэмж олгож, холбогдох санхүүгийн тооцоог хийж дуусгахыг Нягтлан бодогч /Б.Номин-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Ч.Аюурзанатай ажил хүлээлцэх комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлыг актаар хүлээлцүүлэхийг Ажил хүлээлцэх комисс /Х.Энх-Амгалан/-д даалгасугай. Үүнд:

Комиссын ахлагч:

Х.Энх-Амгалан - Менежер;

Гишүүд:

Б.Номин-Эрдэнэ - Нягтлан бодогч;

Г.Золжаргал - Мэргэжилтэн

Ж.Батбаяр - Мэргэжилтэн;

Ц.Энхчимэг - Нярав

4. Тушаалыг холбогдох ажилтанд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн менежер /Х.Энх-Амгалан/-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ж.ОСОРЖАМАА

013 000038